

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний  
төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/157/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> (Баянхонгор хот)</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор: Б.Цэрэнчимэд. Утас: 88117644 Цахим хаяг: <a href="mailto:tserenchimedb@sudit.gov.mn">tserenchimedb@sudit.gov.mn</a> Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p>
------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал .....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.02.07 № 1/156

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

Г Аудитын гэрчилгээ 7

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН УС, 7  
ЦАГ УУР ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
ДАРГА Ч.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил

D:\СТА-2019\УЦУОШГазар\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

005020015

гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\СТА-2019\УЦҮОШГазар\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

## 2.1. Оршил

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Ч.Оюунчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 16-наас 2020 оны 01 дүгээр сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Ус, цаг уур, орчны шинжилгээний үнэн зөв мэдээллээр хэрэглэгчийг хангах, байгаль цаг агаарын болзошгүй аюул, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэрэмжлүүлэх, цаг агаар, уур амьсгалын нөөцийг бүрэн дүүрэн ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэжээ.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд 31 гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 31 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 25 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1138380,4 мянган төгрөгөөс тооцон 22767,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг, төлөвлөлтийн шатанд тооцсон 22767,6 мянган төгрөгөөр тооцож баталгаажуулав.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 116003,5 мянган төгрөгөөр буюу 13,34 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	2,366.20	803.90	(1,562.30)
Урьдчилгаа			-
Бараа материал	146,861.70	226,958.00	80,096.30
Үндсэн хөрөнгө	720,414.60	757,884.10	37,469.50
хуримтлагдсан элэгдэл			-
Нийт хөрөнгө	869,642.50	985,646.00	116,003.50
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	869,642.50	985,646.00	116,003.50
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	869,642.50	985,646.00	116,003.50

Авлага дансны үлдэгдэл буурсан нь оны эхэнд байсан 2366,2 мянган төгрөгийн авлагаас тайлант онд 1562,3 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, 2013 онд үүссэн иргэн Э.Жагваралын холбоотой 803,9 мянган төгрөгийн авлага үлдэгдлээр байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 80096,3 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГазрын 2019.12.24-ний А-1/4362 тоот албан бичгээр үндсэн хөрөнгийн бүртгэлд байсан 95802,7 мянган төгрөгийн хөрөнгийг эргэлтийн хөрөнгийн дансанд шилжүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбоотой байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4206,8 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГазрын 2019.12.17-ны 618 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө

оруулалтаар бий болсон 91999,9 мянган төгрөгийн үнэ бүхий Баянговь сумын цаг уурын өртөөний барилгыг үндсэн хөрөнгөнд нэмэгдүүлсэн, системийн дээд байгууллагаас 8009,6 мянган төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг компьютер шилжүүлж өгсөнтэй холбоотой байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 985646,1 мянган төгрөг болж 116003,5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн хэмжээгээр нэмэгдсэн байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын төсвийн тухай хуульд зааснаар Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 онд 200,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1410,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 1210,0 мянган төгрөгөөр давсан нь орлогын төлөвлөгөөг бага тогтоосонтой холбоотой байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 673658,8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 673658,8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар санхүүжүүлсэн байна.

Нийт зардлын 1005316,8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 200,0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1005516,8 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа бөгөөд зарцуулаагүй үлдсэн 143,4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан болохыг харуулж байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт санхүүжилтийн дансаар системийн дээд байгууллагаас 2019 онд УЦУОШТөвийн Байдраг өртөөний барилгын сангийн шугам хоолойн засварын ажилд зориулж 2,0 сая төгрөг, аймгийн ИТХ-ын 2018.11.29-ны 14/03 тоот тогтоолоор цаг агаарт нөлөөлж хур тундас оруулахад зориулж 20,0 сая төгрөг баталж санхүүжилтээр олгосон байна. Мөн үндсэн үйл ажиллагааны орлогоор 1410,0 мянган төгрөгийн орлого орсон байна. Нэмэлт орлогоор орсон 1410,0 мянган төгрөгөөс 3,1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 1406,9 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд системийн дээд байгууллага Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2019.12.16-ны 2/881, 2019,12,20-ны 01/899 тоот албан бичгээр зарцуулжээ.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл тодорхойлж, үнэлж нийт 26 горим сорил нарийвчлан хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 130,4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 16,7 сая төгрөгийн алдааг залруулж, 1,5 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 112,2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 заалт бүхий зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 113,7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Засгийн газрын 2015.05.11-ний 184-р тогтоолын 2 дахь заалт, мөн аймгийн Засаг даргын 2013.06.05-ны 327 тоот захирамжаар батлагдсан журмын 3.1 "...агентлагууд болон бусад төсвийн байгууллагын үйлчилгээний автомашины нэг өдрийн гүйлтийн лимит төв суурин газарт 10 км ..." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс 480,5 мянган төгрөгийн зөрчил гаргасан нь "Хэмжилт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. Цалингаас Шүүхийн шийдвэрээр суутгасан суутгалыг ШШГАлбанд шилжүүлэхдээ 41752 төгрөг илүү шилжүүлсэн, мөн Ажиллагсдын цалингаас суутгасан хуримтлалын сангийн мөнгийг банкны хуримтлалын харилцах данс руу шилжүүлэхдээ 100000 төгрөгийг илүү шилжүүлж санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

3. Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагааны орлогоос давсан орлого 1410,0 мянган төгрөгөөс 502,0 мянган төгрөгийг зарцуулах эрхийг Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 20-ны 01/899 тоот албан тоотоор авч, зарцуулсан ба тайлант оны эцэст 3,1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, үлдэх 904,9 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулахдаа зөвшөөрөлгүй зарцуулж, Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны 74 тоот тушаалаар батлагдсан журмын 4.1.1 "төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрт харьяалагдах төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн саналыг нэгтгэн хянаж .... санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгжид 7-р сарын 15 болон 11-р сарын 10-ны дотор тус тус хүргүүлнэ", 4.1.3 "төсвийн төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж ... жил бүрийн 8-р сарын 10 болон 11-р сарын 25-ны дотор Сангийн сайдын тушаалаар шийдвэрлүүлж, ... хүргүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байгаа нь "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн 112,2 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- 1) Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны лаборторийн үйлчилгээний орлогоор 1410,0 мянган төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд орсныг Цаг уурын орчны шинжилгээний газрын даргын 2019.12.16-ны 2/881, 2019.12.20-ны 01/899 тоот албан бичгийн дагуу аймгийн Төрийн санд санхүүжилтийн эрх нээлгэж зарцуулсан ба энэ нь Сангийн Сангийн сайдын 2019.11.22-ны 251 тоот тушаалаар батлагдсан төсвийн зарлагын хэмнэлт зарцуулах тухай тушаалын 1-р хавсралтыг БОАЖ-ын сайдын Цаг уур орчны шинжилгээний газар 8308,5 мянган төгрөгт багтаж байгаа гэсэн тайлбар өгсөн тул Цаг уурын орчны шинжилгээний газрын ТЕЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар авч үзэх шаардлагатай болно.
- 2) Дараагийн аудитаар Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн харьяа сумдад үйл ажиллагаа явуулж буй салбаруудад олгож байгаа түлшний мод, нүүрс олголт, зарцуулалт, үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын талаар анхаарч авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 133 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	3	2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	87	9	
	Нийт	27	151	136	13	2

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1950,1 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоосноос 1950,1 мянган төгрөгийг барагдуулсан, 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах

Бид Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### “Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Авлагын данстай холбоотой асуудал

**1.1 Илрүүлэлт:** Авлага дансны үлдэгдэлд 2366,2 мянган төгрөгийн авлагаас тайлант онд 1562,3 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, 2013 онд үүссэн иргэн Э.Жагваралын холбоотой 803,9 мянган төгрөгийн авлага үлдэгдлээр байна.

**1.2 Эрсдэл:** Авлагын насжилт уртсаж, хөрөнгө мөнгө үрэгдэх

**1.3 Өгсөн зөвлөмж:** Иргэн Э.Жагваралын холбоотой 803,9 мянган төгрөгийн авлага бүрэн барагдуулж, барагдаагүй тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлэх.

**1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Цаашид алдааг давтан гаргахгүй, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

## **2 Тооцооны данстай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:** Сангийн сайдын 388-р тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар "журмын 3.6-ийн б "Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ" гэсэн журмыг мөрдөөгүйгээс цалингаас суутгасан НДШ, ХХОАТ-аас бусад суутгалын 103992,7 мянган төгрөгийг "Бусад өглөг"-ийн дансаар бичилт хийлгүй "Цалингийн өглөг" дансанд бичилт хийсэн.

**2.2. Эрсдэл:** "Бусад өглөг"-ийн дансаар дамжуулаагүйгээс илүү, дутуу шилжүүлж, авлага, өр төлбөр үүсэх

**2.3. Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 388-р тушаалаар батлагдсан журмын 3.6-ийн б "Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ" гэсэн журмыг хатуу мөрдөж, дансны бичилтийг зөв хийж байх.

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Цаашид алдааг давтан гаргахгүй.

## **3.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд хөрөнгийн ангиллыг буруу илэрхийлж, Программ хангамжийг Бусад үндсэн хөрөнгийн ангилалд оруулж тайлагнасан, зарим үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын тооцооллыг буруу тооцоолж данс бүртгэлд тусгасан.

**3.2. Эрсдэл:** Үндсэн хөрөнгийн үнэ, цэнэ, ач холбогдлыг алдагдуулах

**3.3. Өгсөн зөвлөмж:** УЦУОГТөвийн НББББаримт бичгийн 4.5 "Биет бус хөрөнгийн бүртгэл", 4.5.1.3 "Биет бус хөрөнгийн ангилал: Газар эзэмших эрх, Компьютерийн программ хангамж гэсэн заалтыг хэрэгжүүлж, хөрөнгийн ангиллыг санхүүгийн болон үндсэн хөрөнгийн тодруулга тайланд зөв тусгаж, хөрөнгийн элэгдлийн зардлыг зөв тооцож бүртгэл тайланд тусгаж байх.

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>149,227,967.72</b>	<b>227,761,917.67</b>
33	<b>АВЛАГА</b>	2,366,233.27	803,919.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,352,917.27	00.00
335	<b>Бусад авлага</b>	1,013,316.00	803,919.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,013,316.00	803,919.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	146,861,734.45	226,957,998.67
351	<b>Түүхий эд материал</b>	104,930,940.78	193,049,711.02
35110	Тусгай зориулалттай материал	104,930,940.78	193,049,711.02
354	<b>Хангамжийн материал</b>	41,930,793.67	33,908,287.65
35410	Бичиг хэргийн материал	705,636.41	498,936.41
35420	Аж ахуйн материал	34,212,757.78	29,183,921.76
35430	Сэлбэг хэрэгсэл	784,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	6,228,399.48	4,225,429.48
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>720,414,600.01</b>	<b>757,884,144.38</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	720,414,600.01	757,884,144.38
392	<b>Биет хөрөнгө</b>	494,272,600.01	531,742,144.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	430,894,893.20	522,894,788.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-27,288,406.82
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,941,400.00	36,941,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-36,356,399.83	-36,941,400.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	429,111,812.53	341,318,745.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-378,585,861.16	-314,771,179.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,573,239.08	26,573,239.08
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,565,650.46	-21,674,208.90
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,842,719.00	7,842,719.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,583,552.35	-3,153,552.31
393	<b>Биет бус хөрөнгө</b>	226,142,000.00	226,142,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	226,142,000.00	226,142,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>869,642,567.73</b>	<b>985,646,062.05</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>869,642,567.73</b>	<b>985,646,062.05</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	869,642,567.73	985,646,062.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	587,740,743.91	587,740,743.91
51101	Өмч: - төрийн	587,740,743.91	587,740,743.91
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-77,784,066.15	44,776,628.17
51210	Өмнөх үеийн үр дүн	-77,784,066.15	-71,226,866.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	116,003,494.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	359,685,889.97	353,128,689.97
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>869,642,567.73</b>	<b>985,646,062.05</b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>984,281,480.61</b>	<b>1,254,383,909.21</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>75,904,496.61</b>	<b>225,512,909.21</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>75,904,496.61</b>	<b>225,512,909.21</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	75,319,809.12	225,512,909.21
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	75,119,809.12	225,312,909.21
120009	Бусад орлого	584,687.49	00.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>908,376,984.00</b>	<b>1,028,871,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>880,362,100.00</b>	<b>1,005,461,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	880,362,100.00	1,005,461,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>20,938,000.00</b>	<b>23,410,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,000,000.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,000,000.00
131105	Төсвийн саигууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд оои болсон нэмэлт орлого	938,000.00	1,410,000.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>7,076,884.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	7,076,884.00	00.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>994,683,294.43</b>	<b>1,138,380,414.89</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>994,683,294.43</b>	<b>1,138,380,414.89</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>981,267,770.43</b>	<b>1,133,138,172.89</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>740,326,631.00</b>	<b>847,479,456.00</b>
210101	Үндсэн цалин	605,824,099.00	676,031,256.00
210102	Нэмэгдэл	107,958,390.00	142,521,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,544,142.00	28,927,100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>88,901,330.22</b>	<b>106,102,257.27</b>
210201	Тэтгэврийн даатгал	59,078,600.00	72,247,657.27
210202	Тэтгэмжийн даатгал	7,386,100.00	8,463,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,317,930.22	6,770,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,346,400.00	1,692,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,772,300.00	16,927,300.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>22,683,111.00</b>	<b>23,502,302.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,238,687.00	4,731,200.00
210302	Түлш, халаалт	18,149,424.00	18,696,102.00
210303	Цэвэр, бохир ус	295,000.00	75,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,587,044.68</b>	<b>38,545,124.39</b>
210401	Бичиг хэрэг	1,287,800.00	2,994,100.00
210402	Тээвэр, шатахуун	14,694,354.00	14,060,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,908,791.00	2,219,259.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,131,810.00	551,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	25,800.00	1,768,979.00
210408	Бараа материал акталсны зардал	5,538,489.68	16,950,436.39
2105	<b>Нормативт зардал</b>	<b>1,160,550.00</b>	<b>00.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,160,550.00	00.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>46,480,454.79</b>	<b>33,853,905.60</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,029,754.79	30,871,832.60
210604	Урсгал засвар	3,450,700.00	2,982,073.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,393,800.00</b>	<b>4,443,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,393,800.00	4,443,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,313,352.00	16,671,327.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,164,403.00	15,470,727.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	277,200.00	277,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	392,397.00	401,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,800.00	111,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	24,700.00
210807	Газрын төлбөр	331,552.00	386,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,421,496.74	62,540,000.63
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,421,496.74	62,540,000.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,415,524.00	5,242,242.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,204,384.00	5,095,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,967,896.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,236,488.00	5,095,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	211,140.00	147,242.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,140.00	147,242.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-10,401,813.82	116,003,494.32
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,818,535.94	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,209,571.93	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	5,608,964.01	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-6,818,535.94	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-17,220,349.76	116,003,494.32

/төгрөг/

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	908,576,984.00	1,029,071,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200,000.00	200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	200,000.00	200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,000.00	200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	200,000.00
120009	Бусад орлого	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	908,376,984.00	1,028,871,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	880,362,100.00	1,005,461,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	880,362,100.00	1,005,461,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,938,000.00	23,410,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,000,000.00	20,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	938,000.00	1,410,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,076,884.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	7,076,884.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	906,805,234.00	1,029,071,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	906,805,234.00	1,029,071,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	893,389,710.00	1,023,828,758.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	738,496,115.00	846,223,599.00
210101	Үндсэн цалин	603,463,915.00	673,515,399.00
210102	Нэмэгдэл	104,845,100.00	142,521,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,187,100.00	30,187,100.00

Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,623,100.00	105,795,800.00
210201	Тэтгэврийн даатгал	59,078,600.00	71,941,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,386,100.00	8,463,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,908,900.00	6,770,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,477,200.00	1,692,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,772,300.00	16,927,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,325,263.00	22,799,600.00
210301	Гэрэл, цахилгаан	4,238,687.00	4,731,200.00
210302	Түлш, халаалт	17,791,576.00	17,993,400.00
210303	Цэвэр, бохир ус	295,000.00	75,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,855,385.00	8,361,859.00
210401	Бичиг хэрэг	1,037,940.00	1,037,700.00
210402	Тээвэр, шатахуун	4,470,100.00	4,970,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,181,300.00	2,219,259.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	166,045.00	134,800.00
2105	Нормативт зардал	464,500.00	464,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	464,500.00	464,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,970,050.00	3,341,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,259,200.00	1,312,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	22,100.00	66,300.00
210604	Урсгал засвар	1,688,750.00	1,962,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,443,800.00	4,443,800.00
210702	Дотоод албан томилолт	4,443,800.00	4,443,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,117,597.00	31,303,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,976,948.00	30,099,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	277,200.00	277,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	392,397.00	401,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,800.00	114,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,700.00	24,700.00
210807	Газрын төлбөр	331,552.00	386,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,093,900.00	1,093,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,093,900.00	1,093,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,415,524.00	5,242,242.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,204,384.00	5,095,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	7,076,884.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,127,500.00	5,095,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	211,140.00	147,242.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,140.00	147,242.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,771,750.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,771,750.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,771,750.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,771,750.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,771,750.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,771,750.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	361,598,743.91	106,096,171.75	90,423,263.49	558,118,179.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>361,598,743.91</b>	<b>106,096,171.75</b>	<b>90,423,263.49</b>	<b>558,118,179.15</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,688,787.43	-15,688,787.43
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	359,685,889.97	-77,784,066.15	869,642,567.73
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	359,685,889.97	-77,784,066.15	869,642,567.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	6,557,200.00	6,557,200.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>587,740,743.91</b>	<b>359,685,889.97</b>	<b>-71,226,866.15</b>	<b>876,199,767.73</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-6,557,200.00	00.00	-6,557,200.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	116,003,494.32	116,003,494.32
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	353,128,689.97	44,776,628.17	985,646,062.05

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН</b>	1,005,661,000.00	1,005,516,858.00	-144,142.00	99.99
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,005,661,000.00	1,005,516,858.00	-144,142.00	99.99
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ</b>	1,000,566,000.00	1,000,421,858.00	-144,142.00	99.99
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл</b>	846,367,000.00	846,223,599.00	-143,401.00	99.98
210101	Үндсэн цалин	673,658,800.00	673,515,399.00	-143,401.00	99.98
210102	Нэмэгдэл	142,521,100.00	142,521,100.00	0.00	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,187,100.00	30,187,100.00	0.00	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн да</b>	105,795,800.00	105,795,800.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	71,941,200.00	71,941,200.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,463,700.00	8,463,700.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,770,900.00	6,770,900.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,692,700.00	1,692,700.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,927,300.00	16,927,300.00	0.00	100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоото</b>	22,799,600.00	22,799,600.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,731,200.00	4,731,200.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	17,993,400.00	17,993,400.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	75,000.00	75,000.00	0.00	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын</b>	8,361,900.00	8,361,859.00	-41.00	100.00
210401	Бичиг хэрэг	1,037,700.00	1,037,700.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	4,970,100.00	4,970,100.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернети	2,219,300.00	2,219,259.00	-41.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэ	134,800.00	134,800.00	0.00	100.00

2105	Нормативт зардал	464,500.00	464,500.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эд	464,500.00	464,500.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын	3,341,800.00	3,341,800.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,312,700.00	1,312,700.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	66,300.00	66,300.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	1,962,800.00	1,962,800.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	4,443,800.00	4,443,800.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	4,443,800.00	4,443,800.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	7,897,700.00	7,897,000.00	-700.00	99.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил	6,692,900.00	6,692,900.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зөвшөөрөл	277,200.00	277,200.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	402,000.00	401,300.00	-700.00	99.83
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,800.00	114,800.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,700.00	24,700.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	386,100.00	386,100.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1093900.00	1093900.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даатгал	1,093,900.00	1,093,900.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5095000.00	5095000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,095,000.00	5,095,000.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэмэгдэл	5,095,000.00	5,095,000.00	0.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСЭЛ</b>	<b>1,005,661,000.00</b>	<b>1,005,516,858.00</b>	<b>-144,142.00</b>	<b>99.99</b>
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,005,461,000.00	1,005,316,858.00	-144,142.00	99.99
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,005,461,000.00	1,005,316,858.00	-144,142.00	99.99
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГА	200,000.00	200,000.00	0.00	100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	200,000.00	200,000.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	90	90	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01	01	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	83	83	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	06	06	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	90	90	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагчид	90	90	0.00	100.00

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Б.ЦЭРЭНЧИМЭД

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

*(Handwritten signatures and red official stamps are present here, including a stamp with the number 43544 and 9007423.)*